

1

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БУЙ СТАНДАРТ,
НОРМ НОРМАТИВ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГТ
НЭГДСЭН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН
АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН**

Зам, тээврийн салбарын стандарт, норм, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/236 дугаар тушаалаар байгуулан ажилласан.

Дээрх үзлэгтэй холбогдуулан зам, тээврийн салбарт хамаарах стандартыг тус ажлын хэсэгт цахимаар ашиглах боломжийг бүрдүүлж өгөхийг хүсэлтийг Стандарт, хэмжил зүйн газарт 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Стандарт, хэмжил зүйн газраас 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр авто замын 222, автотээврийн 135, төмөр зам, усан замын тээврийн 175, иргэний нисэхийн 13 нийт 545 стандартыг pdf хэлбэрээр Судалгаа, стандарт, статистикийн хэлтэст ирүүлснийг тухайн өдөр дэд хэсгийн дарга, нарийн бичиг нарт хүргүүлэн ажиллалаа. Түүнчлэн 2018 онд хийсэн зам, тээврийн салбарын стандартын үзлэгийн тайланг холбогдох салбарын ажлын дэд хэсэгт өгсөн болно.

Дээрх стандартын үзлэгийн тайлан, мэдээлэлд тулгуурлан авто замын 317, автотээврийн 133, төмөр зам, далай ашиглалт ба усан замын тээврийн 175, иргэний нисэхийн 23 нийт 648 стандартад үзлэг хийж, 4 дэд ажлын хэсгийн тайланг ирүүлснийг нэгтгэн танилцуулж байна. Дэд салбарын тайланг тус бүрээр хавсаргав.Үүнд:

Авто замын салбар

2018 онд зохион байгуулсан "Үндэсний стандартын шинжлэх ухаан, техникийн түвшин тогтоох улсын үзлэг"-т авто замын салбарт нийт 255 стандарт хамрагдсан бөгөөд үүнээс 67 стандартыг дахин хянах, 8 стандартыг шинээр боловсруулах, 24 стандартын холбогдох заалтыг хүчингүй болгох, 2 стандартыг шууд олон улсын стандартаар орлуулан хэрэглэх шаардлагатай гэж үзэж байсан. Авто замын салбарт 2018 оноос хойш нийт 46 стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулснаас 27 нь стандарт, 19 нь норм, норматив, техникийн баримт бичиг байна.

Авто замын салбарын ажлын дэд хэсэг нь нийт 317 стандарт (Олон улсын 13, бүс нутгийн 9, гадаадын 208. Үндэсний 87 стандарт), 58 норм, техникийн баримт бичигт үзлэг хийсэн байна. Тус үзлэгийн тайлангаас үзэхэд 20 стандартыг хүчингүй болгох, 21 стандартыг дахин хянах, шинээр 29 стандарт боловсруулах шаардлагатай гэж үзсэн байна. Нормд хийсэн үзлэгээс харахад 7 нормыг дахин хянах, 27 нормыг шинээр боловсруулах шаардлагатай гэж ажлын хэсэг дүгнэсэн байна.

Автотээврийн салбар

Монгол Улсын стандартын мэдээллийн санд 1983-2022 оны байдлаар батлагдан, бүртгэгдсэн 133 (Олон улсын 57, бүс нутгийн 1, гадаадын 1, Үндэсний 74) стандарт болон Улаанбаатар хотын стандартын цахим мэдээллийн сан <https://standard.ub.gov.mn/standards/>-д байрших д салбарт хамаарах 6 стандартын хамт нийт 138 стандартад Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/236 тушаалын "Ажлын хэсгийн ажиллах удирдамж" 2 дугаар хавсралтын дагуу дараах байдлаар

улсын үзлэгийг хийжээ. Тус үзлэгийн тайлангаас үзэхэд 1 стандартыг хүчингүй болгох, 15 стандартыг дахин хянах, шууд олон улсын стандартаар орлуулах 10 стандарт, шинээр 13 стандарт боловсруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна. Түүнчлэн тус салбарын болон салбар дундын нийт 49 стандартыг нэмж судлах шаардлагатай гэж үзсэн байна.

Төмөр зам, далай ашиглалт ба усан замын тээврийн салбар

Ажлын хэсэг нь төмөр замын салбарын 167 стандарт, далай ашиглалт ба усан замын тээврийн салбарын 8 буюу нийт 175 (Олон улсын - 9, Бүс нутгийн - 100, гадаад орны - 11, үндэсний – 55) стандартын 7000 орчим хуудас материалд үзлэг хийсэн. Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны “Үндэсний стандартын улсын үзлэгийн арга зүйн заавар батлах тухай” А/182 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтууд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын А/236 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад заасан удирдамжийн дагуу маягтуудыг бөглөж, нэгдсэн тайлан дүнг боловсруулан гаргажээ. Нийт стандартын 69.14% буюу 121 стандарт нь 2015 оноос хойш боловсруулсан стандарт байгаа нь төмөр зам, далай ашиглалт ба усан замын тээврийн салбарын стандартын боловсруулалт сүүлийн үед нэлээд эрчимтэй хийгдснийг харуулж байна.

Тус үзлэгийн тайлангаас үзэхэд нийтэд нь дахин хянах 11, холбогдох заалтуудыг дахин хянах 58, шинээр 6 стандарт боловсруулах шаардлагатай гэсэн байна. Вагоны аж ахуй, замын аж ахуй, галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийнтөвлөрүүлэлт, дохиолол холбооны чиглэлээр нийт 8 техникийн зохицуулалтыг шинээр боловсруулах санал гарсан.

Иргэний нисэхийн салбар

Иргэний нисэхийн салбарын ажлын хэсэг нь салбарын одоо мөрдөгдөж байгаа нийт 23 стандарт, 2 техникийн баримт бичгийн хэрэгжилтийг цахим болон материалаар хэлбэрээр хүлээн авч, үзлэг хийсэн. Тус үзлэгийн тайлангаас үзэхэд хүчингүй болгох 1, нийтэд нь дахин хянах, шинээр 1 стандарт, 2 техникийн баримт бичиг боловсруулах шаардлагатай гэж үзсэн байна. Түүнчлэн салбар дундын нийт 73 стандартад үзлэг хийж, дахин хянах шаардлагатай 8 стандарт байгааг тогтоосон байна.

Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийн мөрөөр хийж авч хэрэгжүүлэх ажил, цаашид анхаарах санал

1. Зам, тээврийн салбарын нийт 648 стандарт, 60 норм, техникийн баримт бичигт нэгдсэн үзлэг хийсэн байна. Автотээврийн салбарын 43-р ангиллаас гадна үйл ажиллагаанд шууд хамаарах *Хүрээлэн байгаа орчин 13.020, Резин дугуй 83.160, Тээвэрлэлтийн үйл ажиллагаа 03.220, Хуванцар эдлэл; “Тээврийн шатсан хийн бохирдол”* ангилалтын код 13.040.50-ийн 23 стандартыг үзлэгт хамруулах;
2. Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийн мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд оруулах саналаа ажлын дэд хэсгүүд 2023 оны 12 дугаар сарын 01-ны дотор Судалгаа, стандарт, хэмжил зүйн газарт ирүүлэх, тэдгээрийг нэгтгэн уг төлөвлөгөөг батлуулах;

3. Зам, тээврийн салбарын 4 стандартчиллын техникийн хорооны 2024-2025 оны хөтөлбөр-төлөвлөгөөнд хүчингүй болгох, дахин хянах, шинээр болон шинэчлэн боловсруулах стандартын саналыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Стандарт, хэмжил зүйн газраас гаргасан хүснэгтийн дагуу боловсруулан Судалгаа, стандарт, статистикийн хэлтэст ирүүлэх;
4. Авто замын салбарын норм норматив, техникийн баримт бичгийн хэдийг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн санд бүртгүүлэх шаардлагатайг судалгааг АЗБЗГ гаргаж ирүүлэх
5. Шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа салбарын норм, техникийн баримт бичгийг 2024 оны тухайн хариуцагч газар, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
6. ЗТХ-ийн сайдын 2020 оны А/220 дугаар тушаалаар өгөгдсөн авто замын 11 нормыг боловсруулж батлуулах ажлыг эрчимжүүлэх,
7. Зам, тээврийн салбарт шаардлагатай техникийн зохицуулалтыг холбогдох хууль, журмын дагуу боловсруулж батлуулахыг салбарын бодлого, зохицуулалтын газруудад үүрэг болгох;
8. Засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинээр болон шинэчлэн батлах техникийн зохицуулалтын жагсаалт"-ын 16 дахь заалтыг үндэслэн ЗТХ-ийн сайдын "Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалтын аюулгүй байдлын техникийн зохицуулалтыг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" 2020 оны А/175 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын даргад даалгах
9. Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор дээрх салбарт ашиглагдаж буй журам, стандарт, норм, дүрэм, техникийн баримт бичгийг уялдуулах, ялангуяа нэр томьёо, тодорхойлолтыг цэгцлэх;
10. Зам, тээврийн салбарын стандарт, норм, техникийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог сайжруулах;
11. Зам, тээврийн салбарын стандартыг салбарын албан хаагчдад болон олон нийтэд сурталчлан таниулах сургалт, сурталчилгааг үе шаттай зохион байгуулах;
12. Авто замын норм нормативын сангийн ажиллах журмыг шинэчлэн батлуулах, тус сангийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, зөвлөх компанийн боловсруулж байгаа стандарт, норм, техникийн баримт бичгийн чанарт анхаарах, цаг хугацаанд гүйцэтгүүлэх, талаар хяналт тавьж ажиллах;
13. Зам, тээврийн салбарын нэгдсэн платформд стандарт, норм, техникийн баримт бичгийн жагсаалтыг оруулах, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах

ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА,
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА,
СССХ-ИЙН ДАРГА

Ц.МЯДАГМАА



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/236

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ.

1. Зам, тээврийн салбарын эрх зүйн орчны шинэчлэл, Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангахтай уялдуулан зам, тээврийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийг зохион байгуулах Ажлын хэсэг, Ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар, Ажлын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайланг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (С.Батболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /А.Мөнхбат/-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

5

Зам, тээврийн хөгжлийн
сайдын 2023 оны 18 дугаар
сарын 20 ны өдрийн 1/186
тушаалын нэгдүгээр хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БУЙ
СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГТ
НЭГДСЭН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	- С.Батболд	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.
Ажлын хэсгийн дэд дарга:	- Б.Бат-Өлзий	Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын дарга.
Гишүүд:	- Ц.Одхүү	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын даргын УТОГ
	- Б.Болор-Эрдэнэ	Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
	- А.Мөнхбат	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
	- Ч.Сугармаа	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга;
	- Э.Мөнхнасан	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга;
	- Х.Итгэлт	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга;
	- С.Мяндасмаа	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга;
	- Д.Төрмөнх	Стандарт, хэмжил зүйн газрын ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр);
	- Х.Пүрэвжаргал	"Зам, тээврийн хөгжлийн төв" Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал.
Нарийн бичгийн дарга:	- Ц.Мядагмаа	Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, статистик, стандартын хэлтсийн дарга.

НЭГ. АВТО ЗАМЫН САЛБАРЫН
АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	- Ч.Сугармаа	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга.
Нарийн бичиг:	- Х.Энэрэлсайхан	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн.
Гишүүд:	- Б.Цэрэнсодном	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын шинжээч;
	- Ц.Хосгэрэл	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн;
	- Ж.Оюунжаргал	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн;
	- С.Баярчимэг	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн;
	- Б.Дархандарьяа	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн;
	- У.Эрдэнэбаатар	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн;
	- Д.Заансүх	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн;
	- Л.Баярбат	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн;
	- Ц.Батжаргал	Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын Улсын ахлах байцаагч;
	- Б.Гантөмөр	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч;
	- Я.Ганцэцэг	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн;
	- Д.Базарсад	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, норм нормативын хэлтсийн дарга;
	- Г.Анхцэцэг	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Бодлогын хэрэгжилт, зураг



ХОЁР. АВТО ТЭЭВРИЙН САЛБАРЫН
АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	- Э.Мөнхнасан	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга.
Нарийн бичиг:	- А.Батчулуун	"АТҮТ" ТӨҮГ-ын Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн чанарын ахлах мэргэжилтэн.
Гишүүд:	- А.Энхболд	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын Авто тээврийн салбарын стандарт, техникийн зохицуулалт, сургалт хариуцсан мэргэжилтэн;
	- Ц.Санчирдорж	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн;
	- П.Мөнхбат	Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын Улсын ахлах байцаагч;
	- О.Нямхүү	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч;
	- Д.Оюунсүрэн	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн шинжээч;
	- П.Эрхэмбаяр	"АТҮТ" ТӨҮГ-ын Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн ахлах мэргэжилтэн;
	- О.Батцоож	Нийтийн тээврийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн Авто тээврийн хяналтын улсын байцаагч;
	- Ж.Аюуш	Монголын тээвэрчдийн нэгдсэн холбоо ТББ-ын менежер /тохиролцсоноор/;
	- А.Зоригтбаатар	Зөвлөх /тохиролцсоноор/.



ГУРАВ. ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН
АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН


Ажлын хэсгийн дарга:	- Х.Итгэлт	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга.
Нарийн бичиг:	- Ц.Наранчимэг	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч.
Гишүүд:	- Д.Жавхлан	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга;
	- Л.Булганхүү	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч;
	- Ж.Болдхүү	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч;
	- Б.Идэр	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн;
	- Д.Батхүү	Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын Улсын ахлах байцаагч;
	- Л.Шинэчимэг	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч;
	- Я.Ганцэцэг	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн;
	- А.Буяннэмэх	"ГТХЗНТ" УТҮГ-ийн захирал;
	- Ш.Нямсүрэн	"УБТЗ" ХНН-ийн Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан орлогч дарга;
	- С.Мөнх-Алдар	"УБТЗ" ХНН-ийн Техникийн бодлого, стандартчилалын албаны дарга;
	- Г.Анхбаяр	"ТТЗ" ХХК-ийн ерөнхий инженер;
	- Т.Батзориг	"МТЗ" ХХК-ийн ерөнхий инженер;
	- Т.Олонбаяр	Далайн захиргааны Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн.



ДӨРӨВ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРЫН
АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	- Ц.Одхүү	Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.
Нарийн бичиг:	- Б.Эрдэнэзаяа	Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн.
Гишүүд:	- М.Туяа	Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч;
	- Э.Мөнх-Эрдэнэ	Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын аеродромын мэргэжилтэн;
	- П.Гантөгс	Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер;
	- С.Батзул	Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын үйлчилгээний газрын мэргэжилтэн.
	- Д.Баярмаа	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч;
	- Я.Ганцэцэг	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн.

---oOo---



Зам, тээврийн хөгжлийн
сайдын 2023 оны 08 дугаар
сарын 30 ны өдрийн 14 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БУЙ СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГТ НЭГДСЭН ҮЗЛЭГ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1.Зам, тээврийн салбарын хууль эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэл, Монгол Улсын Их хурал, Засгийн газраас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зам, тээврийн салбарын зорилго, зорилт, үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглүүлэн салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичигт нэгдсэн үзлэг хийж, тайлан, дүгнэлт гаргаж, цаашид боловсронгуй болгох чиглэлээр арга хэмжээний санал боловсруулна.

Хоёр. Үр дүн

2.1.Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийг зохион байгуулах ажлын үр дүнд дараах баримт бичгүүдийг боловсруулна.

2.1.1.Зам, тээврийн салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн болон салбар тус бүрээр хийсэн үзлэгийн тайлан, дүгнэлт, санал, танилцуулга;

2.1.2. Зам, тээврийн салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийн мөрөөр хийж, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөний төсөл.

Гурав. Ажлын хэсгийн гүйцэтгэх ажил үүрэг

3.1.Ажлын хэсэг нь дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.

3.1.1.Зам, тээврийн салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлнэ;

3.1.2.Дэд ажлын хэсгүүдийн тайланг хянан үзэх, хөгжлийн бодлогын зорилго, чиглэлтэй нийцүүлэн сайжруулах талаар ажлын дэд хэсэгт чиглэл өгөх, зөвлөмж гаргах, нэгтгэн боловсруулна;

3.1.3.Нэгдсэн үзлэгийн мөрөөр хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулна;

3.1.4.Үр дүнг Сайд болон бусад шаардлагатай түвшинд танилцуулж, хэлэлцүүлнэ.

3.2.Ажлын дэд хэсэг нь дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ.

3.2.1.Салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн жагсаалтыг бүрэн гаргана;

3.2.2.Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн жагсаалтад үндэслэн үзлэгийг /салбар дундын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийг оролцуулан/ 4.3-т заасан маягтын дагуу хийнэ;

3.2.3. Холбогдох салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн үзлэгийн дүнг нэгтгэн боловсруулж, холбогдох дүгнэлт, саналыг агуулсан тайлан гаргаж, танилцуулга, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулах саналын хамт төлөвлөгөөнд заасан хугацаанд Ажлын хэсэгт хүргүүлнэ;

3.2.4. Тайланд Монгол Улсын хэмжээнд 2018 онд зохион байгуулсан "Үндэсний стандартын шинжлэх ухаан, техникийн түвшин тогтоох улсын үзлэг"-ийн дүн, тайлангийн хэрэгжилттэй уялдуулан дүн шинжилгээ хийж тусгасан байна;

3.2.5. Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн жагсаалтад үндэслэн үзлэгийн үр дүнг Сайд болон бусад шаардлагатай түвшинд танилцуулж, хэлэлцүүлнэ.

Дөрөв. Үзлэгийн заавар аргачлал, маягт

4.1. Салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн үзлэгийг хийхдээ баримт бичгийн шинжилгээний чанарын болон агуулгын аргачлалын дагуу боловсруулсан 4.3-т заасан маягтыг ашиглана.

4.2. Баримт бичгийн шинжилгээгээр гарч ирсэн үр дүнг нэгтгэн тайлан боловсруулах ба боломжтой өгөгдлийг ашиглан бүрэн дүн шинжилгээ хийсэн байна.

4.3. Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн үзлэгийн маягт нь дараах загвар, бүтэц, агуулгатай байна. Үүнд:

4.3.1. Салбарт мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн үзлэг хийх маягтын загвар:

**Салбарт мөрдөгдөж буй
стандартын үзлэг хийх маягт №1.1**

Д/д	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Ангилалтын код	Стандартын төрөл				Эрх зүйн байдал	
				Бүтээгдэхүүний	Шинжилгээний арга, аргачлал	Нэр томъёо	Бусад	Заавал мөрдөх техникийн зохицуулалт	Сонгон хэрэглэх
0	1	2	3	4	5	6	7	8	9

**Салбарт мөрдөгдөж буй норм, норматив,
техникийн баримт бичгийн үзлэг хийх маягт №1.2**

Д/д	Баримт бичгийн нэр	Шифр	Тушаал, шийдвэрийн огноо, дугаар /баталсан субъект/	Төрөл				Эрх зүйн байдал	
				Бүтээгдэхүүний	Аргазүй, аргачлалын	Техникийн	Бусад	Заавал мөрдөх техникийн зохицуулалт	Сонгон хэрэглэх
0	1	2	3	4	5	6	7	8	9



4.3.2.Салбарт мөрдөгдөж буй стандартын шинжлэх ухаан техникийн түвшний судалгааны маягтын загвар:

**Салбарт мөрдөгдөж буй стандартын
шинжлэх ухаан техникийн түвшний судалгааны маягт №2**

Д/д	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Ангилалтын код	Шинжлэх ухаан техникийн түвшин							Цаашдын эрх зүйн байдал	
				Олон улсын	Бус нутгийн	Гадаад орны	Үндэсний	Хотын	Байгууллагын	Цаашдын хүрэх түвшин	техникийн зохицуулалт болгох	Сонгон хэрэглэх болох
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

4.3.3.Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн мөрдөлт, хэрэглээний судалгааны маягтын загвар:

**Салбарын стандартын мөрдөлт,
хэрэглээний судалгааны маягт №3.1**

Д/д	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Стандартын худалдан авсан, татан авсан тоо									Тайлбар, үндэслэл
			2016 он хүртэл нийт	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Нийт	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

**Салбарын норм, норматив, техникийн баримт бичгийн
мөрдөлт, хэрэглээний судалгааны маягт №3.2**

Д/д	Баримт бичгийн нэр	Шифр	Баримт бичгийг худалдан авсан, татан авсан тоо									Тайлбар, үндэслэл
			2016 он хүртэл нийт	2017	2018	2019	2020	2021	2022	2023	Нийт	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

4.3.4.Салбарт мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийг дахин хянах судалгааны маягтын загвар:

**Салбарт мөрдөгдөж буй стандартыг
дахин хянах судалгааны маягт №4.1**

Д/д	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Дахин хянах хэлбэр					Үндэслэл, тайлбар		
			Дахин хянах шаардлагагүй	Хүчингүй болгох шаардлагатай	Нийтэд нь дахин хянах шаардлагатай	Холбогдох заалтуудыг дахин хянах шаардлагатай	Шууд олон улсын стандартаар орлуулах	Бусад стандартуудтай давхцсан, зөрчилдсөн эсэх	Нэр томъёо, бичлэг тэмдэглэгээ оновчтой эсэх	Бусад /техник, технологийн хоцрогдол... г.м/
0	1	2	3	4	5	6	7	8	9	10

Салбарт мөрдөгдөж буй норм, норматив,



техникийн баримт бичгийг дахин хянах судалгааны маягт №4.2

Д/д	Баримт бичгийн нэр	Шифр	Дахин хянах хэлбэр					Үндэслэл, тайлбар		
			Дахин хянах шаардлагагүй	Хүчингүй болгох шаардлагатай	Нийтэд нь дахин хянах шаардлагатай	Холбогдох заалтуудыг дахин хянах шаардлагатай	Шууд стандартаар орлуулах	Бусад баримт бичигтэй давхцсан, зөрчилдсөн эсэх	Нэр томъёо, бичлэг тэмдэглэгээ оновчтой эсэх	Бусад
0	1	2	3	4	5	6	7	8	9	10

4.3.5.Салбарт шинээр боловсруулах шаардлагатай стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн судалгааны маягтын загвар:

Шинээр боловсруулах шаардлагатай стандартын судалгааны маягт №5.1

Д/д	Стандартын нэр	Шинжлэх ухаан техникийн түвшин	Стандартын төрөл				Эрх зүйн байдал		Үндэслэл, шаардлага	
			Бүтээгдэхүүний	Шинжилгээний арга, аргачлал	Нэр томъёо	Бусад	Заавал мөрдөх техникийн зохицуулалт	Сонгон хэрэглэх	Хууль, эрхзүй, бодлогын баримт бичгийн заалт	Бусад
0	1	2	3	4	5	6	7	8	9	10

Шинээр боловсруулах шаардлагатай норм, норматив, техникийн баримт бичгийн судалгааны маягт №5.2

Д/д	Баримт бичгийн нэр	Баримт бичгийн төрөл				Эрх зүйн байдал		Үндэслэл, шаардлага	
		Бүтээгдэхүүний	Шинжилгээний арга, аргачлал	Нэр томъёо	Бусад	Заавал мөрдөх техникийн зохицуулалт	Сонгон хэрэглэх	Хууль, эрхзүй, бодлогын баримт бичгийн заалт	Бусад
0	1	2	3	4	5	6	7	8	9

---oOo---



Зам, тээврийн хөгжлийн
сайдын 2023 оны 08 дугаар
сарын 30 ны өдрийн 1 дүгээр
тушаалын гуравдугаар хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГТ
НЭГДСЭН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэх ажлын задаргаа	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	Нэгдсэн үзлэг ажлыг удирдлага, байгуулах арга зүйгээр хангах, уялдуулан зохицуулах	Ажлын хэсгийн хурал зохион байгуулах	2023.08.30- 2023.09.05	Ажлын хэсэг
2.		Холбогдох баримт бичиг, мэдээллийг нээлттэй болгох, Ажлын дэд хэсгүүдэд тараах	2023.08.30- 2023.09.05	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
3.		Салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн жагсаалтыг гаргах	2023.09.01- 2023.09.08	Ажлын дэд хэсгүүд
4.	Салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичигт үзлэг хийх	Салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн жагсаалтад үндэслэн маягтын дагуу үзлэг хийх	2023.09.08- 2023.09.29	Ажлын дэд хэсгүүд
5.		Үзлэгийн дүнг нэгтгэн боловсруулж, холбогдох дүгнэлт, саналыг агуулсан тайлан гаргаж, танилцуулга, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулах саналын хамт Ажлын хэсэгт хүргүүлэх	2023.10.02- 2023.10.06	Ажлын дэд хэсгүүд
6.		Дэд ажлын хэсгүүдийн тайланг хянан үзэх, сайжруулах талаар санал, зөвлөмж гаргах	2023.10.09- 2023.10.13	Ажлын хэсэг
7.	Нэгдсэн үзлэгийн тайлан, төлөвлөгөөний саналыг нэгтгэх, танилцуулах	Нэгдсэн үзлэгийн тайланг сайжруулах, танилцуулгын ppt-г эцэслэх	2023.10.16- 2023.10.18	Ажлын дэд хэсгийн дарга, нарийн бичиг
8.		Нэгдсэн үзлэгийн тайлан, үзлэгийн мөрөөр хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулах	2023.10.16- 2023.10.18	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
9.		Үр дүнг Сайд болон бусад шаардлагатай түвшинд танилцуулж, хэлэлцүүлэх	2023.10.20	Ажлын хэсэг, Ажлын дэд хэсгүүд

АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ СТАНДАРТЫН ҮЗЛЭГИЙН ТАЙЛАН

2023.09.29

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/236 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын эрх зүйн орчны шинэчлэл, Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангахтай уялдуулан зам, тээврийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн нэгдсэн үзлэгийг зохион байгуулах Авто замын салбарын ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүн тус салбарт хамаарах стандартын улсын үзлэгийг зохион байгууллаа.

Монгол Улсын хэмжээнд 2018 онд зохион байгуулсан "Үндэсний стандартын шинжлэх ухаан, техникийн түвшин тогтоох улсын үзлэг"-ээр Авто замын салбарт нийт **255** стандарт бүртгэгдсэн байгаа бөгөөд үүнээс **67** стандартыг дахин хянах, **8** стандартыг шинээр боловсруулах, **24** стандартын холбогдох заалтыг хүчингүй болгох, **2** стандартыг шууд олон улсын стандартаар орлуулан хэрэглэх шаардлагатай гэж үзсэн байгаа бөгөөд мөн зөрчил, дутагдлууд болон баримтлах бодлого, хүндрэлтэй асуудлуудыг шийдэх арга замын талаар доорх хэлбэрээр дүгнэсэн байна. Үүнд:

1. Авто замын салбарын хууль тогтоомжийг өндөр хөгжилтэй улс орнуудын нийтлэг тогтолцоонд ойртуулах, уялдуулах, адил болгох, ажлын хүрээнд гадаадын улс орны туршлагыг судалж нэвтрүүлэх;

2. Авто замын барилга, засвар, зөвлөхийн үйлчилгээнд олон улсын ФИДИК-ийн гэрээний нөхцөлүүдийг тусган стандарт боловсруулах чиглэлээр судалгаа хийх;

3. АНУ, Европын Холбооны дүрэм, журам, заавар, удирдамжийг судалж, тэдгээрээс нэн шаардлагатай нь авто замын салбарт нэвтрүүлэх;

4. Шаардлагатай стандартыг унших, судлах, худалдан авах, орчуулах, боловсруулахад нэн шаардлагатай найдвартай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

5. Шинэчлэх болон шинээр боловсруулах стандартыг судлах, нутагшуулах ажлын хэсгийг зохион байгуулж ажиллах;

6. АНУ болон Европын стандартыг судлах, боловсруулах ажилд мэргэжлийн их, дээд сургууль, төр болон төрийн олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

7. АНУ болон Европын стандартыг боловсруулах мэргэшсэн баг бүрдүүлэх;

8. Салбарын хүрээнд стандартын шинэчлэл хийх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт техникийн баримт бичгүүдийг өөрийн орны онцлог нөхцөлд тохируулан Үндэсний болгон батлуулах;

9. Стандарт баримт бичгүүдийн мөрдөлтийг хангахад хяналт тавихад онцгой анхаарч ажиллах;

10. Авто замын салбарт мөрдөгдөж буй MNS AASHTO болон ASTM-ын стандартуудын зарим үзүүлэлтүүдийг өөрийн орны онцлог нөхцөлд тохируулах боловсруулах судалгаа шинжилгээний ажлыг хийх;

11. Уул уурхайн олборлолт нэмэгдэж байгаатай уялдуулан уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто замын стандартыг өөрийн орны онцлог нөхцөлд тохируулан боловсруулах;

12. Авто замын салбарын стандартчиллын бодлогын хүрээнд цаашид хийх асуудлуудын чиглэл тодорхойлогдсон боловч стандарт боловсруулах ажлын зардал байхгүй ба хүрэлцэхгүй байгаа нь боловсруулан гаргах стандартын хугацаа, чанарт сөргөөр нөлөөлж байна. Иймээс стандартын үзлэгийг үе шаттайгаар тогтмол хийх арга хэмжээ авах, стандартуудыг сурталчлах талаар семинар зохион байгуулах зэрэг арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллах шаардлагатай. Энэ ажлын хүрээнд:

Үндэсний стандартууд хэрэглэгчдийн шаардлага хэрхэн хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, тендерийн баримт бичиг болон техникийн баримт бичгүүдэд хэрхэн тусгагдаж, бусад баримт бичиг болон бусад баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж байгаа талаар үнэлгээ өгөх, шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох стандартуудын жагсаалт гаргаж, цаашдын ажлын төлөвлөгөөнд тусгаж байх, зам, тээврийн салбарт Үндэсний тохирлын тэмдэг, тохирлын гэрчилгээ бүхий бүрэлдэхүүнтэй болох талаарх мэдээлэл, сурталчилгаа хийх, ААНБ-ыг сонгон санал дэвшүүлэх, мөн салбарт ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх боломжтой



байгууллагыг сонгон, нэр дэвшүүлж, санал оруулах, салбарт мөрдөж буй үндэсний стандартуудын эмхтгэл гарган, хэрэглэгч байгууллагуудын хүртээл болгох зэрэг ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн стандартын санхүүжилтийн талаарх асуудлыг шийдүүлэх олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас буцалтгүй тусламж авах хүсэлт гаргах нь зүйтэй гэж үзжээ.

Авто зам, замын байгууламжийн стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, салбарт шинэ техник технологи нэвтрүүлэх судалгааны ажлыг **“Авто замын норм, нормативын сан”**-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тус сангийн жил бүрийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яамны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулах хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам болон салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэдэг зөвлөх инженер, техникийн ажилтнуудаас албан бичгээр санал авч, мөн Стандартын улсын үзлэгийн тайлан, Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон шаардлагад нийцэхгүй зарим шийдвэрийг хүчингүй болгох, хуульд нийцүүлэх талаар Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргасан шийдвэр, Зам, тээврийн хөгжлийн сайдаас баталсан зам, тээврийн салбарт хийгдэх судалгаа, шинжилгээний ажлуудыг тус тус чиглэл болгон авто замын салбарын хэмжээнд нэгтгэн тус сангийн Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн.

Авто замын салбарт 2018 оноос хойш нийт **46** стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулаад байгаагаас **27** нь стандарт, **19** нь норм, норматив, техникийн баримт бичиг байна. (Хавсралт №1-ээс танилцана уу)

Үүнд авто замын салбарын стандартчиллын тогтолцоог өндөр хөгжилтэй улс орнуудын нийтлэг тогтолцоонд ойртуулах, уялдуулах, адил болгох, ажлын хүрээнд гадаадын улс орны туршлагыг судалж **MNS 6598:2016 “Зам, замын байгууламжийн норматив техникийн баримт бичгийн ерөнхий тогтолцоо”** стандартыг шинэчлэн батлуулсан.

Мөн 2007 оноос хойш шинэчлэгдээгүй авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын үйлдвэрлэлийн болон төсвийн нэр бүхий 6 нормыг программын хамт шинэчлэн боловсруулж, батлуулсан.

2023 оны төлөвлөгөөний дагуу **3** стандарт, **16** норм дүрмийг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлуудыг гэрээний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. (Хавсралт №2-оос танилцана уу)

Үүнд авто зам, замын байгууламжийн төсөллөлтийн үндсэн баримт бичиг болох АЗУАГН 2.01.01-2004 “Авто замын уур амьсгал геотехникийн нөхцөл”, ЗЗБНБД 22-004-2016 “Авто зам төсөллөх”, “Авто замын уян хучилтыг төсөллөх тооцооны аргачлал”, БНБД 32-02-11 “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” зэрэг нормыг олон улсын түвшинд нийцүүлэн шинэчилж байна.

Эдгээрийг шинэчлэн батлуулснаар Монгол орны зам цаг уурын бүс, дэд бүсчлэлээр авто зам, замын байгууламжийг төсөллөх болно.

Авто замын салбарын хувьд авто зам, замын байгууламжийн стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, салбарт шинэ техник технологи нэвтрүүлэх судалгааны ажлыг “Авто замын сан”, “Авто замын норм, нормативын сан”-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрх зүйн боломж байдаг хэдий ч одоогоор зөвхөн “Авто замын норм, нормативын сан”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна.

“Авто замын норм нормативын сан”-гийн хөрөнгөөр 2010 оноос хойш сонгон шалгаруулалтаар хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, ирсэн боловч энэ нь олон зүйлээс шалтгаалан сангийн төлөвлөгөөний биелэлт жил бүр 60-80%-н биелэлттэй байна.

Стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг шинэчлэх, шинээр боловсруулах болон салбарын судалгаа, шинжилгээний ажлыг салбарын судалгаа, шинжилгээний асуудал хариуцсан төрийн байгууллагад бүрэн хариуцуулан гүйцэтгүүлдэг, судалгааны байгууллагад судлаачид нэгдэн ажилладаг олон улсын жишигт шилжиж, цаашдын стандарт, норм нормативын тогтолцоог боловсронгуй болгох ажилд шинэчлэлт

хийх хэрэгтэй байна. Иймд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд гарч буй сул тал, тэдгээр нь "Авто замын норм нормативын сан"-гийн төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй зүйлийг тодорхойлж, зарим бодлогын болон зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг авах шаардлага зүй ёсоор тулгараад байна.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль"-ийн хүрээнд дараах асуудлууд үүсч байгаа бөгөөд уг асуудлуудыг шийдвэрлэхээр "Авто замын норм нормативын сангийн ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулаад байна. Үүнд:

1. Салбарын мэргэшсэн хүний нөөцийг бүрэн ашиглахгүй байгаа;
2. Процессын шинжтэй цаг алдагдал их (санал ирүүлсэн оролцогчийн тоо хуулийн шаардлагад нийцээгүйгээс цуцлагдах, дахин зарлах, хүчингүй болдог);
3. Мэргэжлийн хүний нөөцийн тоо эрс цөөрсөн;
4. Судалгааны ажлын залгамж чанар алдагдсан;
5. Судалгаа шинжилгээний хөрөнгө аж ахуйн гэрээгээр эргэн татвар, шимтгэлд суутгагддаг.

Одоогийн нөхцөлд Авто замын салбарын эрдэмтэн, судлаач, инженер техникийн ажилтнууд судалгаа, шинжилгээний ажлыг авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил хэрэгжиж буй төсөлд хэрэглэж, нэвтрүүлэх, хэрэглэсний дараа үр дүнг хэмжих зэргээр хязгаарлагдаж байна.

Түүнчлэн, авто зам, замын байгууламжийн ашиглалтын үеийн чанарын талаар зам хэрэглэгч нараас гомдол тасардаггүй тул чанарын асуудлыг дээшлүүлэхэд зам барилгын материал, хийц эдлэл, материалыг бүрдүүлэгчийг хими, физик, механик шинж чанарыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл одоо байгаа стандарт, норм дүрмийг боловсруулах болон судалгаа, шинжилгээний бодлого, хэрэгжилтийг эрс өөрчлөн эрдэм шинжилгээний суурь судалгааг хөгжүүлэх, үүний тулд Олон улсын түвшинд нийцэхүйц тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байна. /Шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт, техникийн зохицуулалт, норм, дүрмийн жагсаалтыг 5.1, 5.2-т хавсаргав/

Иймд зам, тээврийн салбарын хэмжээний томоохон асуудал тул Зам, тээврийн хөгжлийн яам салбарын эрдэмтэн, судлаач, холбогдох мэргэжилтэн, хуулийн зөвлөхүүдээс бүрдсэн ажлын хэсэг томилон тогтолцоог боловсронгуй болгох ажилд ажиллуулах нь зүйтэй байна.

Хавсралт №1

АВТО ЗАМЫН САЛБАРТ 2018 ОНООС ХОЙШ ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДСАН НОРМ НОРМАТИВ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн нэр	Шифр	
Норм, норматив, техникийн баримт бичиг			
1	Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал	-	2018.05.02, 87, ЗТХС
2	Авто замын барилгын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм	ЗЗБНБД 83-17-2023	2023.05.05, А/141,ЗТХС
3	Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм	ЗЗБНБД 83-25-2023	2023.05.05, А/141,ЗТХС
4	Төмөрөтөн гүүр, хоолойн барилгын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм	ЗЗБНБД 83-4в-2023	2023.05.05, А/141,ЗТХС
5	Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын төсвийн жишиг норм	ЗЗБНБД 83-28-2023	2023.05.05, А/141,ЗТХС
6	Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм	ЗЗБНБД 83-20-2023	2023.05.05, А/141,ЗТХС
7	Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын төсвийн жишиг норм	ЗЗБНБД 83-26-2023	2023.05.05, А/141,ЗТХС
8	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм	ЗЗБНБД 81-013-2019	2019.07.31, 256, ЗТХС
9	Авто зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг	-	2019.07.31, 256, ЗТХС
10	Авто зам, замын байгууламжийн машин механизмын ашиглалтын нэг машин цагийн үнэ	-	2019.07.31, 256, ЗТХС

№	Баримт бичгийн нэр	Шифр	
11	Авто машинаар ачаа тээвэрлэх 1тн.км-ийн жишиг тариф	-	2019.07.31, 256, 3ТХС
12	Авто замын барилга, засвар арчлалтын ажилд СБС төрлийн хам полимер битум барьцалдуулагчийг ашиглан полимер асфальтбетон хучлага барих техникийн норм	-	2019.03.11, 70, 3ТХС
13	Асфальтбетон хучлагыг дахин боловсруулах ба цементээр бэхжүүлсэн суурь барих техникийн норм	-	2019.03.11, 69, 3ТХС
14	Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь барих техникийн норм	-	2019.03.11, 68, 3ТХС
15	Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь барих техникийн норм	-	2019.03.11, 67, 3ТХС
16	Нэмэлттэй хүйтэн асфальтбетон хольц турших аргын заавар	-	2019.06.09, 193, 3ТХС
17	Авто замын асфальтбетон хучлагын засварт хэрэглэх нэмэлттэй хүйтэн аб хольц гарын авлага	Гарын авлага	2019.06.09, 193, 3ТХС
18	Гүүр ба хоолойн барилгын ажлын жишиг техникийн шаардлага	ЗЗБНБДЗЗ-001-2021	2021.08.03, А/123,3ТХС
19	Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг	-	2020.02.27, А/54,3ТХС
Стандарт			
1	Авто замын чанарын хяналт, үнэлгээний стандарт арга	MNS 6807 : 2019	СХЗГ
2	Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурваст хэрэглэх органик барьцалдуулагч материал. Асфальтбетон болон полимерасфальтбетон хольц. Техникийн шаардлага	MNS GOST 9128 : 2019	СХЗГ
3	Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурвасын барилгын ажилд хэрэглэх органик барьцалдуулагч материал. Турших арга	MNS GOST 12801 : 2019	СХЗГ
4	Чулуун мастик асфальтбетон болон асфальтбетон хольц. Техникийн шаардлага	MNS GOST 31015:2019	СХЗГ
5	Авто замын байгууламжийн материал. Эргэлдэгч вискозиметрээр битумын зунгааралтыг тодорхойлох туршилтын арга	MNS AASHTO M 316:2019	СХЗГ
6	Явган хүний зам, талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага	MNS 6808:2019	СХЗГ
7	Дугуй мөрний ховил тодорхойлох туршилтын арга	MNS 6894 : 2021	СХЗГ
8	Байгаль цаг уурын нөхцөлд тохирсон асфальтбетон хучилт төсөллөх. Ерөнхий шаардлага	MNS 6895:2021	СХЗГ
9	Битум холбогчийн нам температурын ашиглалтын үзүүлэлт (PG) -ийг тодорхойлох туршилтын арга.	MNS AASHTO R 49-09:2021	СХЗГ
10	Авто замын байгууламжийн материал. Битумэн холбогчийг ашиглалтын үзүүлэлтээр ангилах. Техникийн шаардлага.	MNS AASHTO M 320 : 2021	СХЗГ
11	Авто замын чиглүүлэгч дохионы шон. Техникийн шаардлага.	MNS GOST 32843 : 2021	СХЗГ
12	Авто замын чиглүүлэгч дохионы шон. Туршилтын арга.	MNS GOST 32844 : 2021	СХЗГ
13	Динамик шилжилтийн реометр (DSR) ашиглаж битум холбогчийн реологийн шинж чанарыг тодорхойлох туршилтын арга.	MNS AASHTO T 315 : 2021	СХЗГ
14	Суперпэйв эзэлхүүний аргаар хольц төсөллөх техникийн шаардлага.	MNS AASHTO M 323:2021	СХЗГ
15	Авто замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага.	MNS 5683 : 2022	СХЗГ
16	Гудамж замын гадаргуун ус зайлуулах сувгийн "П" хэлбэрийн төмөрбетон бүтээгдэхүүний бүтээц, нэр төрөл ба хэмжээ	MNS GOST 32955:2022	СХЗГ
17	Авто замын тэмдэг болон дохионы төмөр бетон шон. Техникийн шаардлага.	MNS 4912:2021	СХЗГ
18	Өнгөт асфальтан хольц.	MNS GB/T 32984 : 2023	СХЗГ
19	"Зам, замын байгууламжийн норматив техникийн баримт бичгийн ерөнхий тогтолцоо"	MNS 6598 : 2023	СХЗГ
20	Битум барьцалдуулагч ашиглалтын үзүүлэлтийг үнэлэх буюу шалгах	MNS AASHTO R 29 : 2023	СХЗГ
21	Авто замын байгууламжийн материал. Битум материалын дээж авах стандарт арга	MNS AASHTO R 66 : 2023	СХЗГ

№	Баримт бичгийн нэр	Шифр	
22	Шугаман бус суналтын туршилтын төхөөрөмжийг ашиглан халуун асфальтбетон хольцын гулсалтын хэв гажилт ба бат бэхийг тодорхойлох туршилтын арга	MNS AASHTO T 322 : 2023	СХЗГ
23	Абсоны аргачлалаар битум барьцалдуулагчийг уусгагч урвалж ашиглан ялгах туршилтын арга	MNS AASHTO R 59 : 2023	СХЗГ
24	Асфальт хольц. Техникийн шаардлага	MNS 1592 : 2023	СХЗГ
25	Цахилгаан соронзон багажаар хөрсний нягт болон чийгийг ажлын талбайд тодорхойлох туршилтын арга	ASTM D 7830/D7830M : 2023	СХЗГ
26	Асфальтан хольц. Турших арга 22-р хэсэг. Дугуйн мөр хэмжих	MNS BS EN 12697 22 : 2023	СХЗГ
27	Халуун асфальтбетон хучлагын нягтыг цахилгаан багажаар аулын талбайд хэмжих. Туршилтын арга	MNS AASHTO T 343 : 2023	СХЗГ

Хавсралт №2

АВТО ЗАМЫН САЛБАРТ ШИНЭЧЛЭГДЭЖ БУЙ СТАНДАРТ, НОРМ НОМРАТИВ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн нэр	Шифр	Батлагдсан
Норм, норматив, техникийн баримт бичиг			
1	Авто замын уур амьсгал геотехникийн нөхцөл	АЗУАГН 2.01.01-2004	2004.11.15, 22, 3ТАЖА
2	Авто зам төсөллөх	ЗЗБНБД 22-004-2016	2016.07.08, 187, 3ТХЯ
3	Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага	ЗЗБНБД 31-008-2016	2016.07.08, 186, 3ТХЯ
4	Хот суурины гудамж зам төлөвлөлт	БНБД 32-01-06	2004, 130, 3ТБХБЯ
5	Авто замын уян хучилтыг төсөллөх тооцооны аргачлал	-	2010.09.10, 313, 3ТБХБЯ
6	Монгол орны асфальт бетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог	-	2010.09.10, 313, 3ТБХБЯ
7	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд үнийн индекс тооцох техник, технологийн заавар	ЗЗБНБД 81-014-2016	2016.10.03, 42, 3ТХЯ
8	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм	ЗЗБНБД 81-013-2019	2019.07.31, 256, 3ТХС
9	Авто зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг	-	2019.07.31, 256, 3ТХС
10	Авто зам, замын байгууламжийн машин механизмын ашиглалтын нэг машин цагийн үнэ	-	2019.07.31, 256, 3ТХС
11	Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын зохион байгуулалтын техникийн дүрэм	ЗЗБНБД 41-011-2016	2016.02.18, 37, 3ТЯ
12	Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, онцгой ажлуудыг гүйцэтгэх хугацааны норм	ЗЗБНБД 41-010-2016	2016.02.18, 37, 3ТЯ
13	Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм	ЗЗБД 84-021-16	2016.04.26, 152/101, СЯ, 3ТХЯ
14	Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын арга технологи	БНБД 13-03-00	2000.11.28, -, 3БЯ
15	Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага	-	2011.08.09, 216, 3ТБХБЯ
16	Авто замын гүүр ба хоолой төсөллөх	БНБД 32-02-11	2012.05.03, 122, 3ТБХБЯ
Стандарт			
1	Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага.	MNS 6444 : 2014	43.020, 93.080.10
2	Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага.	MNS 5342 : 2007	43.040.01
3	Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага.	MNS 5537 : 2016	03.080.30

СТАНДАРТЫН ҮЗЛЭГ ХИЙСЭН:
ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

Ч.СУГАРМАА

Авто замын салбарт мөрдөгдөж буй стандартын үзлэг хийх маягт №1.1

Д/а	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Ангилалтын код	Үндэсний стандартын төрөл					Эрх зүйн байдал		
				Бүтээгдэхүүний	Шинжил-гээний арга, аргачлал	Нэр томъёо	Бусад	Заавал мөрдөх	Сонгон хэрэглэх		
0	1	2	3	4	5	6	7	8	9		
1	Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага	MNS 2568:1983	93.080.40	1	0	0	0	0	1		
2	Бетоны хүйтэн тэсвэрлэлтийг тодорхойлох арга.	MNS 1918 : 1985	91.100.30	0	1	0	0	1	0		
3	Бетоны эзэлхүүний жин, чийглэг, ус шингээлт, сүвэрхэгжилт, ус үл нэвтрүүлэлтийг тодорхойлох арга.	MNS 2122 : 1985	91.100.30	0	1	0	0	1	0		
4	Хүнд бетон. Техникийн нөхцөл.	MNS 1228 : 1987	91.100.30	1	0	0	0	1	0		
5	Хөрс. Дээж авах, савлах, тэсвэрлэх, хадгалах журам.	MNS 2305 : 1994	13.080.20	0	0	0	1	0	1		
6	Барилга байгууламжийн ажилд хэрэглэх дайрга. Ерөнхий техникийн шаардлага.	MNS 0390 : 1998	91.100.01	1	0	0	0	0	1		
7	Газар шорооны ажлын машин - Операторын сургалтанд зориулсан арга зүйн удирдамж	MNS ISO 7130 : 1998	93.080.20	0	1	0	0	0	1		
8	Газар шорооны ажлын машин-Ашиглалт ба засвар үйлчилгээ, механик бэлтгэх сургалт.	MNS ISO 8152 : 1998	93.080.20	0	1	0	0	0	1		
9	Бетон болон бетонон бүтээгдэхүүн. Бетон. Сорьцоор бат бэхийг тодорхойлох арга.	MNS 1272: 1999	91.100.30	0	1	0	0	1	0		
10	Бетон болон бетонон бүтээгдэхүүн. Бетоны бат бэхийг шалгах, үнэлэх зарчим.	MNS 1920 : 1999	91.100.30	0	1	0	0	1	0		
11	Барилга, барилгын материал. Барилгын зуурмаг, турших арга.	MNS 2120 : 1999	91.100.30	0	1	0	0	1	0		
12	Иргэний барилга байгууламж. Замын технологи асфальтбетонд хэрэглэх эрдсийн нунтаг. Техникийн шаардлага.	MNS 4904 - 1 : 2000	93.080.20	0	0	0	1	1	0		
13	Газрын тос, түүнд холбогдох технологи. Нефтийн бүтээгдэхүүн. Задгай тигельд дөл үүсгэх болон асах температур тодорхойлох арга.	MNS 0328 : 2000	75.080	0	1	0	0	1	0		
14	Хөрсний физик шинж чанарыг тодохойлох лабораторийн арга.	MNS 2143: 2000	91.010	0	1	0	0	1	0		
15	Барилгын үйлдвэрлэл. Хөрсний температурыг хээрийн нөхцөлд тодорхойлох арга.	MNS 3944 : 2000	91.010	0	1	0	0	1	0		
16	Нефтийн бүтээгдэхүүн - Битумын зунгааралтыг тодорхойлох туршилт.	MNS 3193 : 2001	75.100	0	1	0	0	1	0		
17	Нефтийн бүтээгдэхүүн - Битумын ууршилттай шингэрүүлэгчийн хэмжээг тодорхойлох туршилт.	MNS 3195 : 2001	75.100	0	1	0	0	1	0		
18	Барилгын материал, хөрс, уулын чулуулагт цацраг идэвхит элемент тодорхойлох гамма спектрометрийн арга.	MNS 5072 : 2001	91.100.02	0	1	0	0	0	1		
19	Нефтийн бүтээгдэхүүн-Битумын зүү шигдэлтийн гүнийг тодорхойлох туршилт.	MNS 5109 : 2001	75.100	0	1	0	0	1	0		
20	Нефтийн бүтээгдэхүүн - Битумын суналтыг тодорхойлох туршилт.	MNS 5110 : 2001	75.100	0	1	0	0	1	0		

21	Барилга, барилгын материал. Цемент - Химийн шинжилгээний арга.	MNS 975 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
22	Замын барилга байгууламж. Авто замын хучилтын хавтан. Техникийн шаардлага.	MNS 1593 : 2002	93.080.20	1	0	0	0	0	0	1
23	Замын байгууламжийн материал. Зам ба аэродромын хучилтанд хэрэглэх /халуун, бүлээн, хүйтэн/ битум эрдсийн хольц. Техникийн шаардлага.	MNS 2185 : 2002	93.080.20	1	0	0	0	0	1	0
24	Замын байгууламжийн материал. Асфальтбетон хольц дахь эрдсийн нунтаг. Шинжилгээний арга.	MNS 2795 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
25	Замын байгууламжийн материал. Битумын хэврэгших температурыг тодорхойлох арга.	MNS 5210 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
26	Замын байгууламжийн материал. Битумын урах температурыг тодорхойлох цагираг бөмбөлгийн арга.	MNS 5211 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
27	Замын байгууламжийн материал. Асфальтан /Битумэн/ бүтээгдэхүүнийг нэрэх туршилтын арга.	MNS 5212 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
28	Замын байгууламжийн материал. Замын шингэн битум. Техникийн шаардлага.	MNS 5230 : 2002	93.080.20	1	0	0	0	0	1	0
29	Замын байгууламжийн материал. Хөрсний ширхэглэлийн бүрэлдэхүүн ба хөрсний тогтмолуудыг тодорхойлох дээжийг хуурай бэлтгэх арга.	MNS ASTM D 421 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
30	Стандарт хүчлэл (600kNm/м3)-ээр хөрсний нягтралын үзүүлэлтүүдийг тодорхойлох лабораторийн арга.	MNS ASTM D 698 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
31	Онгоц нисэх-буух талбайн болон хурдны замуудын хийц үнэлгээг ашиглан хөрс болон хучилтын материалуудыг давтамжтай дискээр туршиход зориулсан стандарт туршилтын арга.	MNS ASTM D 1195 : 2002	91.080.20	0	1	0	0	0	1	0
32	Онгоц нисэх-буух талбайн болон хурдны замуудын хийц үнэлгээг ашиглан хөрс болон хучилтын материалуудыг давтамжгүй дискээр туршиход зориулсан стандарт туршилтын арга.	MNS ASTM D 1196 : 2002	91.080.20	0	1	0	0	0	1	0
33	Замын байгууламжийн материал. Замын суурийн доод үе, суурь болон өргөн үеийн хөрс ба холимог материал. Техникийн шаардлага.	MNS ASTM D 1241:2002	93.080.20	1	0	0	0	0	1	0
34	Хөрсний нягтралт ба хувийн жинг элс-конусын аргаар газар дээр нь тодорхойлох стандарт туршилтын арга.	MNS ASTM D 1556 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
35	Стандарт бус хүчлэл (2700 kNm/м3)-ээр хөрсний нягтралын үзүүлэлтүүдийг тодорхойлох лабораторийн арга.	MNS ASTM D 1557 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
36	Замын байгууламжийн материал. Жижиг ширхэглэлтэй хөрсний чийг ба шигдэлтийн эсэргүүцлийн хамаарлыг тодорхойлох стандарт туршилтын арга.	MNS ASTM D 1558 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
37	Замын барилга байгууламж. Нягтруулсан хөрсний ачаа даацын харьцааг тодорхойлох лабораторийн арга.	MNS ASTM D 1883 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
38	Хөрсний жижиг ширхэглэлийн бүрэлдэхүүн ба хөрсний тогтмол хэмжигдхүүнийг тодорхойлох дээжийг угааж бэлтгэх арга.	MNS ASTM D 2217 : 2002	93.080.20	0	1	0	0	0	0	1

39	Замын байгууламжийн материал. Маршаллын аргаар барьцалдалтыг тодорхойлох. Туршилтын арга.	MNS AASHTO R 12 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
40	Замын байгууламжийн материал. Битум хайрга, чулуутай барьцалдах чанарыг тодорхойлох. Шинжилгээний арга.	MNS AASHTO T 182 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
41	Замын байгууламжийн материал. Хучилтын асфальтан хольцын хамгийн их нягтыг тодорхойлох. Туршилтын арга.	MNS AASHTO T 209 : 2002	93.080.20	0	1	0	0	0	1	0
42	Замын байгууламжийн материал. Зам, гүүрийн барилгын ажилд хэрэглэх хайрга, чулууны ширхэглэлийн бүрэлдэхүүн. Техникийн шаардлага.	MNS AASHTO M 43 : 2002	93.080.20	0	0	0	1	0	1	0
43	Хучилтын асфальтан хольцын хамгийн их нягтыг тодорхойлох. Туршилтын арга	MNS AASHTO T 209 : 2002	93.080.20	0	1	0	0	0	0	1
44	Битум хайрга, чулуутай барьцалдах чанарыг тодорхойлох. Шинжилгээний арга	MNS AASHTO T 182 : 2002	93.080.20	0	1	0	0	0	0	1
45	Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага	MNS 4598 : 2003								
46	Хөрсний чийгийг түргэвчилсэн аргаар тодорхойлох.	MNS 5284 : 2003	91.010.01	0	1	0	0	0	0	1
47	Хөрсний нягтыг зүсэх цилиндрийн аргаар тодорхойлох.	MNS ASTM 5182 : 2003	91.010.01	0	1	0	0	0	0	1
48	Замын байгууламжийн материал. Том дүүргэгч материалын элэгдлийн хэмжээг Лос-Анжелсийн туршилтын төхөөрөмжөөр тодорхойлох.	MNS ASTM C 535 : 2003	93.080.20	0	1	0	0	0	0	1
49	Замын байгууламжийн материал. Дүүжин ашиглан хучилтын гадаргуун эсэргүүцэл тодорхойлох.	MNS ASTM E 303 : 2003	93.080.20	0	1	0	0	0	0	1
50	Замын байгууламжийн материал. Битумэн материалын хөвөлтийг тодорхойлох арга.	MNS AASHTO D 139 : 2003	93.080.20	0	1	0	0	0	0	1
51	Замын байгууламжийн материал. Бетоныг өрөмдөж дээж авах, бат бэхийг тодорхойлох.	MNS AASHTO D 724 : 2003	91.080.20	0	1	0	0	0	0	1
52	Холих аргаар бэлтгэсэн замын хучилтаас дээж авах	MNS ASTM D 979 : 2003	93.080.20	0	1	0	0	0	0	1
53	Замын байгууламжийн материал. Хайрга, дайрганы асгаасан нягт ба ширхэг хоорондын зай тодорхойлох.	MNS AASHTO T 19 : 2003	91.080.20	0	1	0	0	0	1	0
